Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх оюутнуудын мэдлэг, хандлагыг үнэлсэн үр дүн

Б.Цэрэннадмид[1], Ч.Ичинхорлоо[2], Ө.Эрдэнэчимэг[2], Г.Ганхуяг[3]

[1]АШУҮИС, Сувилахуйн Сургууль, АСШУ-ны тэнхим
[2]АШУҮИС, Сувилахуйн Сургууль, СБ-4
[3]АШУҮИС, Сувилахуйн Сургууль, Суурь сувилахуйн тэнхим
Цахим шуудан: Tserennadmid@mnums.edu.mn, Утас: 99133412

Түлхүүр үг:

Эх барихуй
Хөдөлгөөн засалч
Хөдөлмөр засалч
Үнэлгээ

Товч утга:

Үндэслэл: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэдэг нь үйлчлүүлэгчтэй зөв харилцах мөн зөв танин тодруулж, эмийн бүтээгдэхүүний аюулгүй байдал, зүү тариурт хатгуулж гэмтэх зэрэг эмнэлгийн байгууллагын үзүүлж буй тусламжтай холбоотой халдварын эрсдэл, унах эрсдэл, зэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ханган ажиллах нь үйлчлүүлэгч болон тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд алдаа, зөрчил болон осол эндэгдэлд өртөхгүй байхыг хэлнэ. **Зорилго:** Сувилахуйн сургуулийн эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх. **Арга, аргачлал:** Бид судалгааг АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж байгаа 3, 4 дүгээр дамжааны 91 оюутнуудыг хамруулан нэг агшны загвараар тоон судалгааны аргаар, олон улсад туршигдсан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх (PSCSE* Nam Ju Lee нарын 2017) стандарт асуумжийг ашигласан. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдын 87 (95.6%) эмэгтэй, 4 (4%) эрэгтэй байсан бөгөөд дундаж нас 21±1.05 байсан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэхэд М5 буюу “Алдаа, сөрөг үйл явдал, аюулыг хооронд нь ялгаж таньдаг” гэсэн асуултад мэднэ гэж хамгийн өндөр хувьтай (59.3%) хариулсан байна. Хандлагыг үнэлэхэд Х2 буюу Алдаанаас урьдчилан сэргийлэхийн тулд өөрийн гүйцэтгэх үүрэг маш чухал гэсэн асуултад санал нийлж байна гэж хамгийн өндөр хувьтай (53.8%) хариулсан байна. **Дүгнэлт:** 1. Оюутнуудын өөрийн үнэлгээгээр үнэлсэн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн үнэлгээ сайн, хандлагын үнэлгээ сайн (p≥0.001) байсан. 2. Оюутнуудын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн хувьд дамжаа ахих тусам тодорхой нэгж хэмжээнд нэмэгдэж байгаа боловч хандлагын хувьд дамжаа ахих тусам төдийлөн нэмэгдэхгүй байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох үйлчлүүлэгчийн аюулгүй байдал алдагдах нь үйлчлүүлэгчид болон тусламж үйлчилгээг үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтэнд өндөр эрсдэлтэй. 2023 оны байдлаар Монгол улсын хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 13947 сувилагчийн 10 мянган хүн амд ноогдох сувилагч мэргэжилтний тоо 41.0 бол 1000 хүн амд ноогдох сувилагч мэргэжилтний тоо 4.1 байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх явцад тухайн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллах нь эрүүл мэндийн байгууллагын нэн тэргүүнд баримтлан ажиллах ёстой зарчим бөгөөд сүүлийн жилүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний хомсдол бий болж ажлын байран дахь ачаалал, стресс нэмэгдсэнээр үйлчлүүлэгчийн аюулгүй байдал алдагдах нэг гол шалтгаан болж байна.

Дэлхий нийтийн хэмжээнд жилд 421 сая хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг ба тэдгээрээс 42.8 сая орчимд урьдчилан сэргийлэх боломжтой эмнэлгийн тусламж үйлчилгээний алдаанаас болж үйлчлүүлэгчийн аюулгүй байдал алдагдсан тохиолдол бүртгэгдсэн байна. Түүнчлэн дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 10 үйлчлүүлэгч

тутмын нэг нь эмнэлгийн алдаанаас болж хохирдог гэх тооцоолол гарсан байна.

Оюутнуудад үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэх нь суралцагчид эмнэл зүйн дадлага хийх, төгссөний дараа ажлын байранд ажиллах явцад алдаа, зөрчил гаргахгүй байх зэрэгт чухал нөлөөг үзүүлнэ. Иймээс бид Сувилахуйн сургуулийн эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг сонгон авч үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг хандлагыг үнэлэх хэрэгцээ байгаа гэж үзэж энэхүү судалгааг хийх болсон.

Зорилго: Сувилахуйн сургуулийн эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх.

Зорилт:

1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх оюутнуудын мэдлэг, хандлагыг үнэлэх
2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх оюутнуудын мэдлэг болон хандлагыг харьцуулах

Арга, аргачлал: Судалгааны мэдээ, материалыг АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооны хурлаар зөвшөөрсөн "Таниулсан зөвшөөрлийн хуудсыг" танилцуулж, судалгаанд сайн дураар хамрагдахыг зөвшөөрч, гарын үсэг зурсан оюутнуудыг сонгон 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 02 дугаар сарын хугацаанд, олон улсад туршигдсан (PSCSE* Nam Ju Lee нарын боловсруулсан, 2017) асуумжийг цаасан хэлбэрээр бэлтгэж, судалгаанд оролцогчдоор бөглүүлэн, тоон судалгааны аргаар хийж, үр дүнгийн үзүүлэлтийг боловсруулахдаа статистикийн үндсэн аргуудыг ашиглалаа.

Үр дүн: Судалгаанд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр 3 болон 4 дүгээр дамжаанд суралцаж буй 20-23 насны нийт 91 оюутан хамрагдлаа. Судалгаанд оролцогчдын 87 (95.6%) эмэгтэй, 4 (4%) эрэгтэй байсан бөгөөд дундаж нас 21±1.05 байсан.

1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх оюутнуудын мэдлэгийн асуумжийн 2 бүлэг 6 асуумжид хариулсан үр дүнг нэгтгэн дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэгийн үзүүлэлт

Мэдлэг (1-6)	Огт мэдэхгүй	Мэдэхгүй байна	Дунд зэрэг мэднэ	Мэднэ	Маш сайн мэднэ
	n (%)	n (%)	n (%)	n (%)	n (%)
M1	0 (0%)	2 (2.2%)	18 (19.8%)	44 (48.4%)	27 (29.7%)
M2	0 (0%)	2 (2.2%)	16 (17.6%)	45 (49.5%)	28 (30.8%)
M3	0 (0%)	5 (5.5%)	21 (21.3)	41 (45.1%)	24 (26.4%)
M4	8 (8.8%)	11 (12.1%)	20 (22.0%)	37 (40.7%)	15 (16.5%)
M5	0 (0%)	1 (1.1%)	18 (19.8%)	54 (59.3%)	18 (19.3%)
M6	2 (2.2%)	2 (2.2%)	23 (25.3%)	48 (52.7%)	15 (17.6%)

Судалгаанд оролцогчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх M1 буюу "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг мэднэ" (тухайлбал багаар ажиллах, манлайлал, үр дүнтэй эерэг харилцаа, эргэх холбоо гэх мэт) гэсэн асуултад 44 (48.4%) нь мэднэ, M2 буюу "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх хүний хүчин зүйлсийг мэднэ" (бие махбод, сэтгэлзүй гэх мэт) гэсэн асуултад 45 (49.5%) нь мэднэ, M3 буюу "Технологи, мэдээллийн менежментийн давуу болон хязгаарлагдмал нөлөөллийг мэднэ" (тухайлбал: бар код, цахим эмнэлгийн бүртгэл, тариурын шахуурга, автомат дохиолол гэх мэт гэсэн асуултад 41 (45.1%) нь мэднэ, M4 буюу "Багийн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд удирдлагын хэвтээ болон босоо тогтолцоо хэрхэн нөлөөлдгийг мэднэ" гэсэн асуултад 37 (40.7%) нь мэднэ, M5 буюу "Алдаа, сөрөг үйл явдал, аюулыг хооронд нь ялгаж таньдаг" гэсэн асуултад 54 (59.3%) нь мэднэ, M6 буюу "Алдаанд дүн шинжилгээ хийх үйл явцыг тодорхойлж мэднэ" гэсэн асуултад 48 (52.7%) нь мэднэ гэж хамгийн өндөр хувьтай хариулсан байна.

2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх хариулсан үр дүнг нэгтгэн дараах хүснэгтээр харуулав. оюутнуудын хандлагын асуумжийн 4 бүлэг 14 асуулгад

Хүснэгт 2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх хандлагын үзүүлэлт


Хандлага (X1-14)	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй байна	Дунд зэрэг санал нийлнэ	Санал нийлж байна	Бүрэн санал нийлнэ
	n (%)	n (%)	n (%)	n (%)	n (%)
X1	0 (0%)	2 (2.2%)	17 (18.7%)	47 (51.6%)	25 (27.5%)
X2	0 (0%)	1 (1.1%)	11 (12.1%)	49 (53.8%)	30 (33.0%)
X3	0 (0%)	0 (0%)	14 (15.4%)	46 (50.5%)	31 (34.1%)
X4	0 (0%)	0 (0%)	7 (7.7%)	39 (42.9%)	45 (49.5%)
X5	0 (0%)	2 (2.2%)	9 (9.9%)	45 (49.5%)	35 (38.5%)
X6	0 (0%)	1 (1.1%)	13 (14.3%)	42 (46.2%)	35 (38.5%)
X7	0 (0%)	2 (2.2%)	11 (12.1%)	34 (37.4%)	44 (48.4%)
X8	0 (0%)	0 (0%)	11 (12.1%)	45 (49.5%)	35 (38.5%)
X9	0 (0%)	2 (2%)	5 (5.5%)	39 (42.9%)	44 (49.5%)
X10	0 (0%)	2 (2%)	19 (20.9%)	33 (36.3%)	37 (40.7%)
X11	29 (31.9%)	24 (26.4%)	16 (17.6%)	15 (16.5%)	7 (7.7%)
X12	41 (45.1%)	29 (31.9%)	6 (6.6%)	10 (11.0%)	5 (5.5%)
X13	0 (0%)	3 (3%)	9 (9.9%)	46 (50.5%)	33 (36.3%)
X14	0 (0%)	0 (0%)	10 (11.0%)	42 (46.2%)	39 (42.9%)

Судалгаанд оролцогчдын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх хандлагыг үнэлэх X1 буюу “Технологи болон мэдээллийн менежментийн арга хэрэгслийг ашиглах” (жишээ нь: үйлчлүүлэгчийн код, эмнэлгийн цахим систем, тарилгын шахуурга, автомат дуудлагын хонх, сэрүүлэг гэх мэт) гэсэн асуултад 47 (51.6%) нь санал нийлж байна, X2 буюу Алдаанаас урьдчилан сэргийлэхийн тулд өөрийн гүйцэтгэх үүрэг маш чухал гэсэн асуултад 49 (53.8%) нь санал нийлж байна, X3 буюу Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг сайжруулахад туслах мэдээллийн технологийн үнэлгээ, хэрэгжилт, сонголт, төлөвлөлт зэрэгт сувилагчийн оролцоо маш чухал гэсэн асуултад 46 (50.7%) нь санал нийлж байна,

X4 буюу Стандартыг дагаж мөрдөж ажиллах нь аливаа эрсдэлийг бууруулах ач холбогдолтой (ээлж солилцох, тусламж үйлчилгээ үзүүлэх явцад гэх мэт) гэсэн асуултад 45 (49.5%) нь бүрэн санал нийлнэ, X5 буюу Эрүүл мэндийн ажилтан нь үйлчлүүлэгч нарт үзүүлэх тусламж үйлчилгээндээ тодорхойгүй байдал үүсгэхгүй байх гэсэн асуултад 45 (49.5%) нь санал нийлнэ, X6 буюу Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах талаарх сургалтыг хөтөлбөртөө оруулах шаардлагатай гэсэн асуултад 42 (46.2%) нь санал нийлнэ, X7 буюу Эрүүл мэндийн ажилтнууд эмнэл зүйн алдаа эндэгдэл, түүний учир шалтгааны талаар тогтмол мэдээллээ солилцох шаардлагатай гэсэн асуултад 44 (48.4%) нь бүрэн санал нийлнэ, X8 буюу Эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэсэн асуултад 45 (49.5%) санал нийлнэ,

X9 буюу Эрүүл мэндийн ажилтнууд ямар ч алдаа дутагдлыг тогтмол мэдээлэх хэрэгтэй гэсэн 44 (49.5%) нь бүрэн санал нийлнэ, X10 буюу эрүүл мэндийн ажилтнууд нь тухайн үйлчлүүлэгч, түүний гэр бүлд алдааны талаар мэдээлэх хэрэгтэй гэсэн асуултад 37 (40.7%) нь бүрэн санал нийлнэ, X11 буюу Үйлчлүүлэгч нарт аюултай байдал үүсээгүй л бол алдааг мэдээлэх шаардлагагүй гэсэн асуултад 29 (31.9%) нь огт санал нийлэхгүй, X12 буюу Хэрвээ би алдаа олж харвал түүнийг өөртөө үлдээнэ гэсэн асуултад 41 (45.1%) нь огт санал нийлэхгүй, X13 буюу Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх боломжтой гэсэн асуултад 46 (50.5%) нь санал нийлнэ, X14 буюу Эрүүл мэндийн ажилтнууд үйлчлүүлэгчийнхээ аюулгүй байдлыг хангахын тулд дэмжлэг үзүүлнэ гэсэн асуултад 42 (46.2%) нь санал нийлнэ гэж тус бүр хамгийн өндөр хувьтай хариулсан байна.

3. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх оюутнуудын мэдлэгийн оноо 0.37 дахин нэмэгдэхэд хандлагын оноо ижил хэмжээгээр нэмэгдэж байна. Мэдлэг болон хандлага нь хоорондоо шугаман хамааралтайгаар аажим өсөж байна. (Зураг 1)



Зураг 1. Оюутнуудын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэг болон хандлагын хоорондын хамаарал

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн асуумж нь хандлагын асуумжтай r= 0.37 дунд (p=0.001) шууд хамааралтай байна.

Хэлцэмж: Судлаач М.Гэрэлтуяа (2023) нарын судалгаанд сувилагч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдлэг, чадвар, хандлагын талаарх онооны ялгааг тодорхойлоход мэдлэгийн онооны хувьд 2 ба 4 дүгээр дамжааны оюутнуудын оноо нь 2 ба 3 дугаар дамжааны оюутнуудын онооноос ялгаатай байжээ.Харин бидний судалгааны үр дүнд мэдлэг хандлагыг үнэлсэн бөгөөд мэдлэгийн хувьд 4 дүгээр дамжааны суралцагч 3 дугаар дамжааны суралцагчдаас ялгаатай, өндөр оноотой, харин хандлагын хувьд 3 дугаар дамжааны оролцогчдоос 4 дүгээр дамжааны оролцогчид ялгаагүй байсан.

Myonghwa P (2011) нар Сувилахуйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын өвчтөний аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлагыг үнэлсэн судалгаандаа эмнэл зүйн дадлага хийсэн 932 төгсөх дамжааны оюутныг оролцуулахад өвчтөний аюулгүй байдлын талаарх мэдлэг харьцангуй бага, хандлага, өөртөө итгэх итгэл дунд түвшинд байжээ. Өвчтөний аюулгүй байдлын талаарх ойлголт, ур чадварыг клиникийн дадлагатай уялдуулан бакалаврын сургалтын хөтөлбөрт системтэйгээр сургах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна.

Nabilou B (2012) нар өвчтөний аюулгүй байдлын талаарх оюутны мэдлэг, хандлагыг үнэлсэн судалгаандаа Урмийн Анагаах Ухааны Их Сургуулийн хүний их эмч, сувилагч, эх барихуйн мэргэжлээр суралцаж байгаа нийт 134 оюутныг хамруулахад оюутнуудын 50% нь өвчтөний аюулгүй байдлын талаарх мэдлэг сайн гэсэн үнэлгээтэй байсан. Анагаах ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудын мэдлэгийн дундаж оноо нь сувилагч, эх барихуйн оюутнуудын дундаж онооноос өндөр бөгөөд мэдэгдэхүйц ялгаатай байлаа. Харин бидний судалгаанд эх барихуй, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж буй оюутнууд хамрагдсан бөгөөд бид мэдлэг болон хандлагыг мэргэжлээр харьцуулаагүй харин мэдлэгийн хувьд 4 дүгээр дамжаа нь 3 дугаар дамжаанаас ялгаатай өндөр оноотой, хандлагын ялгаа ажиглагдаагүй гэсэн үр дүн гарсан.

Nam-Ju Lee (2017) нар БНСУ-ын Сувилахуйн мэргэжлээр төгсөх дамжааны нийт 206 оюутныг хамруулсан судалгаа хийхэд оюутны өвчтөний аюулгүй байдлын талаарх мэдлэг, чадварын түвшин ялгаатай байсан. Сувилахуйн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын хичээлийн агуулгад үйлчлүүлэгч ба өвчтөний аюулгүй байдлын талаар заах аргыг нэмэгдүүлэх, чадварыг ганц лекцийн хичээлийн хүрээнд олж авах боломжгүй ба лаборатори эмнэл зүйн орчинд олон талт заах аргыг боловсруулж, хослуулан хэрэгжүүлэх нь чухал гэсэн дүгнэлт гарчээ. Харин бид судалгаандаа дээрх судалгааны асуумжийг хэрэглэсэн боловч Сувилахуйн сургуулийн сувилагчаас бусад мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг хамруулан, тэдгээрийг хооронд нь харьцуулж үзэхэд суралцагчид мэдлэгийн хувьд дамжаа ахих тусам тодорхой нэгж хэмжээнд нэмэгдэж байгаа боловч хандлагын хувьд дамжаа ахих тусам төдийлөн нэмэгдэхгүй байгаа үр дүн гарсан.

Дүгнэлт:

1. Оюутнуудын өөрийн үнэлгээгээр үнэлсэн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн үнэлгээ сайн, хандлагын үнэлгээ сайн ($p \geq 0.001$) байсан.
2. Оюутнуудын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн хувьд дамжаа ахих тусам тодорхой нэгж хэмжээнд нэмэгдэж байгаа боловч хандлагын хувьд дамжаа ахих тусам төдийлөн нэмэгдэхгүй байна.

Ном зүй:

1. *V. F. Nieva and J. Sorra, "Safety Culture Assessment: A Tool for Improving Patient Safety in Healthcare Organizations," Quality & Safety in Health Care 12 Suppl 2, no. Suppl 2 (December 2003): ii17-23, https://doi.org/10.1136/qhc.12.suppl_2.ii17.*
2. *"Health Development Center Www.Hdc.Gov.Mn," n.d.*
3. *"Nursing AAoCo. AACN Extends National Nurse Faculty Development Initiative with New Funding from the Robert Wood Johnson Foundation," 2013.*
4. *Kim Youngeun, "ICU Nurse Perceptionss of Patient Safety Culture and Patient Safety Competency. Yonsei University.76.," 2020.*
5. *Institute of Medicine (US) Committee on the Health Professions Education Summit, Health Professions Education: A Bridge to Quality, ed. Ann C. Greiner and Elisa Knebel (Washington (DC): National Academies Press (US), 2003), http://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK221528/.*
6. *Carl-Ardy Dubois et al., "Associations of Patient Safety Outcomes with Models of Nursing Care Organization at Unit Level in Hospitals," International Journal for Quality in Health Care: Journal of the International Society for Quality in Health Care 25, no. 2 (April 2013): 110–17, https://doi.org/10.1093/intqhc/mzt019.*
7. *М.Гэрэлтуяа "Үйлчлүүлэгчийн Аюулгүй Байдлын Талаарх Сувилахуйн Оюутны Цогц Чадамжийг Үнэлсэн Нь." Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2023.*
8. *Myonghwa park jeonghye park, "Knowledge, Attiude, Snd Confidence on Patient Safety of Undergraduate Nursing Students," 2014.*
9. *Bahram Nabilou, Aram Feizi, and Hesam Seyedin, "Patient Safety in Medical Education: Students' Perceptions, Knowledge and Attitudes," PloS One 10, no. 8 (2015): e0135610, https://doi.org/10.1371/journal.pone.0135610.*
10. *Nam-Ju Lee, Haena Jang, and Su-Yeon Park, "Patient Safety Education and Baccalaureate Nursing Students' Patient Safety Competency: A Cross-Sectional Study," Nursing & Health Sciences 18, no. 2 (June 2016): 163–71, https://doi.org/10.1111/nhs.12237.*

The results of study of students patient safety knowledge and attitude

Tserennadmid B[1], Ichinkhorloo Ch[2], Erdenechimeg U[2], Gankhuyag G[3]

[1]Department of Basic Medical Science, School of Nursing, MNUMS
[2]BN-48, School of Nursing, MNUMS
[3]Department of fundamental nursing, School of Nursing, MNUMS
E-mail: tserennadmid@mnums.edu.mn, Tel: +976-99133412

Background: Patient safety means proper communication with the client and proper identification, safety of pharmaceutical products, prevention of infection risk, risk of falls, etc., nurses and medical staff are not exposed to errors, violations and accidents.

Aim: To assess the knowledge and attitudes of nursing school midwifery, physical therapist, and occupational therapist students regarding patient safety.

Materials and Methods: We conducted the study with 91 third- and fourth-year students studying midwifery, occupational therapist, and occupational therapist at the School of Nursing using a quantitative survey method with a single-moment design to assess the knowledge and attitudes of internationally tested client safety (PSCSE* Nam Ju Lee et al. 2017) used a standard questionnaire.

Results: When the knowledge score increases by 0.37 times, the attitude score also increases. Knowledge and attitudes are gradually increasing in a linear relationship. The patient's safety awareness questionnaire has a direct correlation with the attitude questionnaire at r= 0.37 (p=0.001).

Conclusion: It is considered necessary to pay attention to the fact that the knowledge of customer safety evaluated by students' self-evaluation increases with the progress of education, but the attitude does not increase with the progress of the course.

Keywords: Midwifery, Physical therapist, Occupational therapist, Assessment